



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Энх Тунх Өрх ӨЭМТ-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/100/НА-СТА-ОНӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга: Г.Нандинжаргал
Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargal.g@audit.gov.mn
Санхүүгийн аудитын албаны ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 11315558 Цахим хаяг: altantsetseg.ya@audit.gov.mn

Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-ийн захирал О.Бурмаа
Утас: 99168735 Цахим хаяг: aetb.audit@gmail.com



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025-05-15 № 731
танай _____-ны № _____-г

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЭНХ ТУНХ ӨРХ ӨЭМТ-ИЙН ДАРГА
Б.БАТХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Энх тунх өрх ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А/84 тоот тушаалаар 37/2025 дугаартай батламжаар "Магадлан итгэмжлэгдсэн" эрүүл мэндийн байгууллага болсон байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Энх тунх өрх ӨЭМТ нь анхан шатны тусламж үйлчилгээний гүйцэтгэлд Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 376.9 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, 14,462 иргэнд эрүүл

мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Энх тунх өрх ӨЭМТ-ийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог 18 байхаар баталж, тайлант онд 14 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тус ӨЭМТ-ийн 2025 оны гурвалсан гэрээний биелэлт 90.2 хувь, ЭМДЕГ-тай байгуулсан эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах гэрээний биелэлт 98.7 хувийн хэрэгжилттэй гэж үнэлэгдсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	2,714,457.21	4,680,642.71
Дансны авлага	5,084,232.95	5,600,183.60
Татвар, НДШ-ийн авлага		516,000.00
Бусад авлага	371,229.65	989,225.90
Бараа материал	29,092,810.08	35,549,743.78
Эргэлтийн хөрөнгийн дүн	37,262,820.89	47,335,795.99
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	99,469,385.53	95,773,981.67
Биет бус хөрөнгө	1,485,000.00	1,320,000.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	100,954,385.53	97,093,981.67
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	138,217,206.42	144,429,777.66
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Дансны өглөг	15,124,356.24	18,127,118.24
Татварын өглөг	4,568,481.08	8,104,798.38
НДШ-ийн өглөг	4,095,667.48	7,990,477.05
Богино хугацаат өр төлбөрийн дүн	23,788,504.80	34,222,393.67
Өр төлбөрийн нийт дүн	23,788,504.80	34,222,393.67
Эзэмшигчдийн өмч		
Хувийн	100,000.00	100,000.00
Хуримтлагдсан ашиг	114,328,701.62	110,107,383.99
Эзэмшигчдийн өмчийн дүн	114,428,701.62	110,207,383.99
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	138,217,206.42	144,429,777.66

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Нийт орлогын дүн	393,719,046.41	387,399,790.47
Санхүүжилтийн орлого	319,616,046.41	376,882,980.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	68,453,000.00	4,220,306.47
Туслах үйл ажиллагааны орлого	5,650,000.00	6,296,504.00
Нийт ашиг (алдагдал)	393,719,046.41	387,399,790.47
Хүүний орлого	56,490.25	61,223.25
Ерөнхий ба удирдлагын зардал	295,059,712.77	393,358,765.61
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	98,715,823.89	(5,897,751.89)
Орлогын татварын зардал	5,649.04	6,122.32
Татварын дараах ашиг (алдагдал)	98,710,174.85	(5,903,874.21)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	98,710,174.85	(5,903,874.21)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	98,710,174.85	(5,903,874.21)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	332,631,470.46	382,663,624.35
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	161,563.00	
Татаас, санхүүжилтийн орлого	326,819,907.46	376,367,120.35
Туслах үйл ажиллагааны орлого	5,650,000.00	6,296,504.00
Бусад мөнгөн орлого		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	332,631,470.46	382,663,624.35
Мөнгөн зарлагын дүн	314,080,900.14	366,362,662.10
Ажиллагчдад төлсөн	259,980,656.70	243,980,876.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,652,505.40	61,582,118.58
Бараа материал худалдан авахад төлсөн	37,140,714.00	22,157,378.00
Ашиглалтын зардалд төлсөн		2,143,527.08
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,950,000.00	1,800,000.00
Татварын байгууллагад төлсөн		20,726,360.12
Бусад мөнгөн зарлага	5,357,024.04	13,972,402.32
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	314,080,900.14	366,362,662.10
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	18,550,570.32	16,300,962.25
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	57,629.04	61,223.25
Хүлээн авсан хүүний орлого	57,629.04	61,223.25
Мөнгөн зарлагын дүн	16,209,950.00	14,396,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	6,798,025.00	14,396,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	9,411,925.00	
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	16,209,950.00	14,396,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(16,152,320.96)	(14,334,776.75)
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	2,398,249.36	1,966,185.50
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	316,207.85	2,714,457.21
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,714,457.21	4,680,642.71

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлсөн капитал	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрв.нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	100,000.00	-	-	-	-	15,617,387.98	15,717,387.98
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-	1,138.79	1,138.79
3	Залруулсан үлдэгдэл	100,000.00	-	-	-	-	15,618,526.77	15,718,526.77
4	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-
8	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	98,710,174.85	98,710,174.85
9	2024 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	100,000.00	-	-	-	-	114,328,701.62	114,428,701.62
10	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-	1,682,556.58	1,682,556.58
11	Залруулсан үлдэгдэл	100,000.00	-	-	-	-	116,011,258.20	116,111,258.20
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-
16	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	(5,903,874.21)	(5,903,874.21)
17	2025 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	100,000.00	-	-	-	-	110,107,383.99	110,207,383.99

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 45,578.3 мянган төгрөгийн 5 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж баталгаажуулсан. Үүнд:

- Цахим орлогын татварын тайланд 61.2 мянган төгрөгийн хүүгийн орлогыг тусгай хувь хэмжээгээр ноогдуулах татварын тооцоололд дутуу тайлагнасныг;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 1,682.6 мянган төгрөгөөр дутуу тооцож тайлагнасныг;
- Татварын ибаримт цахим системд 515.9 мянган төгрөгийн борлуулалтын орлогыг дутуу бүртгэснийг;
- Санхүү байдлын тайланд ААНОАТатварын 516,0 мянган төгрөгийн авлагыг дутуу тайлагнасныг;
- Цахим орлогын татварын тайланд борлуулалтын орлогыг 42,802.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг тус тус залруулав.

Энэ нь НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” болон санхүүгийн тайлагналын “үнэлгээ ба хуваарилалт”, “ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 989.2 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 989.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгөв.

3.2 Зөвлөмж

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Тайлант оны эцэст авлагын үлдэгдэл 989.2 мянган төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж тус тус заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагын эцсийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх зөрчлийг арилган, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Цахим орлогын татварын тайланд 61.2 мянган төгрөгийн хүүгийн орлогыг тусгай хувь хэмжээгээр ноогдуулах татварын тооцоололд дутуу тайлагнасан байна.	1	61.2			1	61,2	1	61.2				
ХАОАТ өглөгийг зардлыг 1,682.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	1,682.6			1	1,682.6	1	1,682.6				
Татварын И-баримт цахим системд 515.9 мянган төгрөгийн борлуулалтын орлогыг дутуу бүртгэж, баталгаажуулсан байна.	1	515.9			1	515.9	1	515.9				
Санхүү байдлын тайланд ААНОАТатварын 516,0 мянган төгрөгийн авлагыг дутуу тайлагнасан.	1	516,0			1	516.0	1	516,0				
Цахим орлогын татварын тайланд борлуулалтын орлогыг 42,802.6 мянган төгрөгөөр, зарлагыг 36,968.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	79770.7			1	79,770.7	1	79,770.7				
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 63.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	63.3			1	63.3	1	63.3				
Дүн	6	82,609.7			6	82,609.7	6	82,609.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант оны эцэст авлагын дансанд бүртгэлтэй 989.2 мянган төгрөгийн авлагын тооцоог нийлж баталгаажуулаагүй байна.	1	989.2					1	989.2
Дүн	1	989.2					1	989.2